

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2023 оны III-р улирал/**

2023 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж буй эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, ажлыг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч, дэмжлэг, үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэв.

УБЕГ-ын өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэн хуулийн этгээдээс өргөдөл, гомдлыг Засгийн газрын <https://zasag.mn> цахим хуудасны 11-11 мэдээллийн төв, УБЕГ-ын фэйсбүүк хаяг, Бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890, бичгээр зэрэг бүх төрлийн хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагад нийт 1597 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнд:

Д/д	Өргөдөл гомдол хүлээн авсан хэлбэр	Тоо	Эзлэх хувь
1	Засгийн газрын 11-11 мэдээллийн төв	442	27.7%
2	Дээд газраас ирүүлсэн	0	-
3	Фэйсбүүк хаяг	0	-
4	Бүртгэлийн нэгдсэн лавлах (1800-1890)	31	1.9%
5	Бичгээр	1123	70.3%
6	Бусад хэлбэрээр (цахим хаяг, НҮНТ, биечлэн уулзсан, утсаар)	1	0.1%
Нийт		1597	100%

Засгийн газрын 11-11 төвд:

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 мэдээллийн төвийн лавлах дугаарт Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 442 өргөдөл гомдол, санал, хүсэлт, талархлыг ирүүлснээс 50.68 хувь нь Нийслэлийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэлийн хэлтэс, төв цэгүүдийн үйл ажиллагаатай холбоотой байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн.

Байгууллагын фэйсбүүк хуудсанд:

“Улсын бүртгэлийн ерөнхий газар” фэйсбүүк хуудсанд энэ оны III улиралд мэдээлэл авах 1302 хандалт ирснийг холбогдох газруудаар нь ангилбал:

Д/д	Нэгжийн нэр	Тоо	Эзлэх хувь
-----	-------------	-----	------------

1	Тамгын газар	-	-
2	Санхүү аж ахуйн хэлтэс	-	-
3	Иргэний улсын бүртгэлийн газар	1,246	95.7 %
4	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар	29	2.2%
5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар	27	2.1%
6	Хяналт шалгалтын газар	-	-
7	Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар	-	-
8	Мэдээллийн технологийн газар	-	-
9	Улсын бүртгэлийн нэгдсэн архив	-	-
10	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	-	-
11	21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	-	-
12	Бусад	-	-
Нийт		1,302	100%

Дээрхээс үзэхэд ирүүлсэн хандалтын 95.7 хувийг Иргэний улсын бүртгэлийн газар эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Төрсний бүртгэл, овог солих, гэрлэлтийн бүртгэл, нас баралтын бүртгэл, регистрийн дугаар засуулах, нэрийн үсгийн алдаа засуулах, үрчлэлтийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл, цахим гадаад паспорт, цахим үнэмлэхтэй холбоотой хандалтууд дийлэнх хувийг эзэлж байна.

Бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 үтсанд:

Тайлант хугацаанд бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 үтсанд ирсэн 23,737 дуудлагад хариу өгсөн.



Авсан дуудлагыг хариуцах чиглэлийн газруудаар харуулбал: ИУБГ-48.1%, ЭХЭБГ-15.8%, ХЭУБГ-10.6% -ийг тус тус эзэлж байгаа ба бүртгэлийн үйл ажиллагаатай (төрсний бүртгэл, овог солих, гэрлэлтийн бүртгэл, нас баралтын бүртгэл, регистрийн дугаар засуулах, нэрийн үсгийн алдаа засуулах, үрчлэлтийн бүртгэл, цахим гадаад паспорт, цахим үнэмлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэл, хуулийн этгээдийг шинээр бүртгүүлэх, хэлбэр

өөрчлөх, салбар бүртгүүлэх, загвар маягт татах, бичиг баримтын зөрчил арилгуулах, баримт бичиг ашигласан тухай, хориг цуцлах, хүүхдийн мөнгө олголттой холбоотой эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлийн лавлагаа мэдээлэл г.м) холбоотой дуудлагууд зонхилж байна.

Хүлээн авч зөвлөгөө мэдээлэл өгсөн дуудлагын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,494-аар нэмэгдсэн бөгөөд гол шалтгаанууд нь үндэсний энгийн цахим гадаад паспорт, цахим үнэмлэх, и-монгол цахим талбар болон сургууль цэцэрлэгийн бүртгэл эхлэхтэй холбоотой шилжилт хөдөлгөөний талаарх дуудлагууд байна.

Бичгээр хүлээн авсан өргөдөл, гомдол:

Тус газарт энэ оны гуравдугаар улиралд 1,123 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд тэдгээрийг хүлээн авсан нэгж тус бүрээр нь танилцуулбал:

Д/д	Нэгжийн нэр	Тоо	Эзлэх хувь
1	Тамгын газар	76	6.8%
2	Санхүү аж ахуйн хэлтэс	6	0.5%
3	Иргэний улсын бүртгэлийн газар	152	13.5%
4	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар	74	6.6%
5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар	21	1.9%
6	Хяналт шалгалтын газар	98	8.7%
7	Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар	0	-
8	Мэдээллийн технологийн газар	3	0.3%
9	Улсын бүртгэлийн нэгдсэн архив	34	3.0%
10	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	5	0.4%
11	21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	654	58.2%
12	Бусад байгууллагын хяналтад байгаа	0	-
Нийт		1,123	100%

Дээрхээс үзэхэд нийт бичгээр ирсэн өргөдөл, гомдлын 58,2% нь 21 аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдэд захиргааны болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор ирсэн өргөдөл, гомдлууд байна.

Улсын бүртгэлийн байгууллагад тайлант хугацаанд ирүүлсэн 1,597 өргөдөл, гомдлын 1.524 (95.4%) шийдвэрлэн хариу өгсөн, хугацаа болоогүй 71, бусад байгууллагад шилжүүлсэн 2 өргөл, гомдол байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өссөн дүн болж байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлыг агуулгаар, дэлгэрэнгүй харуулбал:

№	Агуулга	Тоо	Хувь
1	Тухайн газар, хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ерөнхий зохион байгуулалттай холбоотой хүний нөөцийн асуудлаар	28	1.8
2	ИБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	713	44.7
3	Лавлагаа мэдээлэл болон архивын үйл ажиллагаатай холбоотой	39	2.4
4	Гадаадад зорчих эрхийн улсын бүртгэлтэй холбоотой	65	4.1
5	ЭХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	101	6.
6	ХЭБ-ийн үйл ажиллагаатай холбоотой	118	7.4
7	Бүртгэлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой	187	11.7
8	Төрийн үйлчилгээний цахим машинтай холбоотой асуудлаар /ТҮЦ машинаас олгосон лавлагаагаар бусад байгууллага үйлчлэхгүй байх гэх мэт/	1	0.1
9	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар ирүүлсэн	75	4.7
10	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой /тэмдэгтийн хураамжын буцаалт, гэх мэт/	36	2.3
11	Ажлын байрны орчин нөхцөлтэй холбоотой	7	0.4
12	Албан хаагчийн зан харьцаа, ёс зүйтэй холбоотой ажлын хариуцлага алдсан тухай	32	2.0

13	Албан хаагчийн нийгмийн асуудал болон, хүний нөөцтэй холбоотой асуудал	89	5.6
14	Удирдлага албан тушаалтны үйл ажиллагаа, хариуцлага, ёс зүйн талаар	0	0
15	Бусад	53	3.3
16	Талархал	46	2.9
17	Санал	6	0.4
18	Мэдэгдэл	1	0.1
Нийт		1597	100

2023 оны 3-р улирлын байдлаар УБЕГ-ын хэмжээнд өссөн дүнгээр нийт 5,615 өргөдөл гомдол бүртгэгдсэнээс өргөдөл 1320 (23.5%), хүсэлт 2,639 (47%), санал 19 (0.3%), талархал 143 (2.5%), гомдол 1,493 (26.6%) байна.

---o0o---